



**2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**





КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

“Хөвсгөл Алтандуулга” ХК

| | |
|----------------------------|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 1710001001 |
| Регистрийн дугаар | 2034565 |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 1996.04.25 |
| Үйл ажиллагааны чиглэл | Үр тариа үйлдвэрлэл |
| | Гурил үйлдвэрлэл |
| | Малын тэжээлийн үйлдвэрлэл |
| | Хүнсний ногоо тариалах |
| | Гадаад дотоод худалдаа |
| | Малын аж ахуй |
| | Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 157,342 мянган төгрөг |
| Компанийн хаяг | Хөвсгөл, Тариалан, Мандал |
| Холбоо барих утас | 70386030, 70386055, 77116031 |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо | 327 (2019.04.01 байдлаар) |





КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн ТУЗ-ийн 2019 оны 3-р сарын 12-ны өдрийн хурлын тогтоолд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлын зарыг холбогдох хууль, журмын дагуу өдөр тутмын сонин, өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, танилцах материалыг өөрийн цахим хуудсанд болон үнэт цаасны компаниудад байршууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4-р сарын 23-ны өдөр 87.2 хувийн ирцтэйгээр УБ хотод хуралдаж дараахь асуудлуудыг хэлэлцлээ.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа

ТУЗ нь 9 гишүүнтэй, 2019 оны эхний хагас жилд 2 удаагийн хурал болон 1 удаагийн эчнээ санал хураалтаар дараахь асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 2018 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн урьдчилсан гүйцэтгэл
- Нэмэлт хувьцаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгө, түүний зарцуулалтын тухай
- Тэс трейд ХХК-тай байгуулах сонирхлын зөрчилтэй хэлцэл
- Ногдол ашиг хуваарилах тухай
- 2019 оны үрсгал болон хөрөнгө оруулалтын зардлын төсөв
- 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай
- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дотоод аудитын тайлан, ТУЗ-ийн дүгнэлт
- 2019 оны бизнес төлөвлөгөө
- Арилжааны банкнаас зээл авахыг дэмжих
- Монголын Хөгжлийн Банкнаас хөрөнгө оруулалтын зээл авахыг дэмжих



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал

2019 онд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг өмнөх оныхоос нэмэгдүүлэхгүй (2018 онд нийт 7.9 сая төгрөг олгосон) байхаар ХЭХ-аар шийдвэрлэсэн. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ нь компанийн ерөнхий удирдлагын зардлын батлагдсан төсвийн 1.6% байна.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох чөлөөлөх

Компанийн дүрмээр ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2 жил бөгөөд 2018 онд сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаагүй, шинээр нэр дэвшүүлэх санал гараагүй тул 2019 оны ХЭ-ийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалд ТУЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх асуудал ороогүй болно.

ТОП 20 компанийн засаглалын судалгаа

Компани СЗХ болон МХБ-ийн хамтарсан ТОП 20 компанийн засаглалын судалгаанд хамрагдаж нийт 78 асуултын 75 асуултад 0-4 оноогоор үнэлгээ өгсөн. Энэхүү өөрийн үнэлгээг нэгтгэвэл:

| Асуултын төрөл | Хариулсан асуулт | | | Гүйцэтгэл /хариулсан асуултаас тооцов/ |
|--|------------------|-----------|------------|--|
| | тоо | Дээд оноо | Өгсөн оноо | |
| Ил тод нээлттэй байдал | 15 | 60 | 55 | 91.7% |
| Хувьцаа эзэмшигчдийн эрх ба хувьцаа эзэмшигчдийн хурал | 24 | 96 | 92 | 95.8% |
| Төлөөлөн удирдах зөвлөл | 24 | 96 | 76 | 79.2% |
| Гүйцэтгэх удирдлага | 5 | 20 | 18 | 90.0% |
| Оролцогч талууд | 7 | 28 | 22 | 78.6% |

ТУЗ-ийн дэргэдэх хороод тусгайлсан бодлого, төлөвлөгөөтэй, ТУЗ-ийн гишүүд нь ажлаа үнэлж дүгнэх системтэй, ТУЗ ажлын тайлангаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнадаг байх шаардлагыг бүрэн хангаагүй байгаа нь дээрх үнэлгээг бууруулсан байна. Мөн компани нь хамтран ажиллагч, оролцогч талуудтай холбоотой эдийн засаг, нийгэм болон байгаль орчны асуудлуудын талаарх мэдээллийг ил тод мэдээлдэг байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


| Таримлын төрөл | Тариалалт /га/ |
|-----------------|----------------|
| Улаанбуудай | 4353 |
| Тосны ургамал | 250 |
| Халтар арвай | 20 |
| Овьёос, вандуй | 24 |
| Гурвалжин будаа | 9 |
| Нийт | 4656 |

- 2019 онд бид 4500 га-д тариалалт хийх төлөвлөгөөтэй байсан. Цаг агаарын тааламжтай байдал болон өөрсдийн нөөц бололцоон дээр тулгуурлан тариалах талбайн хэмжээг 156 га-аар нэмэгдүүлэн тариалж, 4656 га тариалалтыг амжилттай хийлээ.
- Үрийн тариалалтанд 212 га уринштай талбайг сонгон тарьялаа. Мөн энэхүү талбайг ХАА-н албан журмын давхар даатгалд хамрууллаа.
- Энэ жилийн газар тариалангийн үйлдвэрлэлд ОХУ-ын органик гаралтай цуврал бордоог ашигласан тул өмнөх жилүүдтэй харьцуулахад бордооны зардал өссөн.
- Уриншийг 2494 га-д хийхээр төлөвлөж, эхний ээлжийн ажлыг хийж гүйцэтгэлээ.
- Ургац хураалтыг богино хугацаанд цаг алдалгүй хийх үүднээс CASE IH Axial FLOW 9240 комбайн, ХОВО үйлдвэрийн өөрөө буулгагч 20 тн даацтай автомашиныг худалдан авлаа.

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

- 2019 оны эхний хагас жилд 3.6 мян тн буудай тээрэмдэж гурил 2.9 мян.тн, тэжээлийн хивэг 0.7 мян тн тус тус үйлдвэрлэсэн байна.
- Бүтээгдхүүний чанарыг сайжруулах үүднээс үйлдвэрийн агаарын дулааны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.
- Үйлдвэрт зарим нэг нэмэлт тоног төхөөрөмжийг суурилуулж, их засварын ажлыг хийсэн.
- Гурилын үйлдвэрийн өргөтгөлийн барилгыг стандартын дагуу барьж ашиглалтанд орууллаа. Ингэснээр үйлдвэрийн ажиллагсдын гал тогоо, хувцас солих, өрөө ариун цэврийн өрөөг шинэчилж үйлдвэрийн хэсэг рүү орох гарах гарцыг бий болгон ариутгалын хэсэгтэй болгосон.
- Лабораторийн өрөөг томруулж заслаа
- Бэлэн бүтээгдхүүний агуулахын шалыг стандартын дагуу будав
- Бүхэл үрийн гурилыг шинжилгээнд хамруулан, хэрэглэгчдэд нийлүүлж эхлэв.
- Үр тарианы агуулах дахь таваарын буудайг дахин шинжилгээнд хамруулж боловсруулах үйлдвэрлэл рүү шилжүүлэх боломжгүй гэсэн нийт 600 тн таваарын буудайг тэжээлд шилжүүлэн борлуулалт хийлээ

2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ /2019:2015/





САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэн 2019 оны санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-өөр батлуулав.
- Дотоод аудиторын зөвлөмжийн дагуу бараа материалын бүртгэл, дотоод мэдээ, тайлангийн системийг оновчтой болгох ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна
- ТУЗ-ийн 2019 оны 2-р сарын 13-ны өдрийн хурлаар компанийн хуримтлагдсан ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу 2019 оны 5-р сарын 1-нээс эхлэн ногдол ашгийг олгож эхэллээ.
- Компани 2019 оны эхний хасагт ХААН банкны зээлээс 0.7 тэрбум төг-ийн зээлийг хуваарьт хугацаанд төлж 6-р сарын 30-ны байдлаар 0.5 тэрбум төг-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. Мал хамгаалах сангаас авсан зээлийн үлдэгдэлийг барагдуулах талаар тодорхой санал боловсруулж ХХААХҮЯ-нд хүргүүлээд байна.

Хөрөнгө, өр төлбөрийн байдал

- Компанийн өөрийн хөрөнгө ногдол ашиг хуваарилснаар 1.9 тэрбум төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний хорогдуулгаар 0.2 тэрбум төгрөгөөр хасагдаж, тухайн үеийн цэвэр ашиг 0.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2019 оны 6-р сарын 30-ны байдлаар 11.4 тэрбум төгрөг болсон байна.
- 2019 оны 6-р сарын 30-ны байдлаар ХААН банкны зээлийн үлдэгдэл 0.5 тэрбум, ХХААХҮЯ-ны МХС-аас авсан зээлийн үлдэгдэл 3.8 тэрбум төг, бусад богино хугацаат өглөг 1.2 тэрбум төг, урт хугацаат өр төлбөр 0.9 тэрбум төг болж, нийт 6.4 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байна.
- Ингэснээр нийт хөрөнгө, өр төлбөр 2019 оны 6-р сарын 30-ны байдлаар 17.8 тэрбум төг болсон байна.
- Компанийн хөрөнгө өр төлбөрийн харьцаа 1/3, эргэлтийн харьцаа 1 байгаа нь зохистой түвшинд байна.





ОРЛОГО ҮР ДҮН

Нийт 4.3 тэрбум төг-ийн борлуулалт хийж, 3.0 тэрбум төгрөгийн өртөг гаргаж, 1.3 тэрбум төг-ийн нийт ашигтай, 0.4 тэрбум төг-ийн борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, 0.1 тэрбум төг-ийн хүүгийн зардалтай, 0.7 тэрбум төг-ийн цэвэр ашигтай ажиллалаа. 2019 оны орлогын төлөвлөгөөний 43%, цэвэр ашгийн төлөвлөгөөний 62%-ийг эхний хагас жилд хэрэгжүүлээд байна. Эхний хагас жилд нийт ашгийн маржин 27%, цэвэр ашгийн маржин 17%-тай байна.

Орлого, үр дүнгийн тайлан 2019 оны эхний хагас

| | Сая.төг |
|---|----------------|
| САНХҮҮГИЙН ОРЛОГО | |
| Үр тариа, тэжээлийн борлуулалт | 775.3 |
| Гурилын борлуулалт | 3,566.8 |
| Бусад | 0.1 |
| НИЙТ САНХҮҮГИЙН ОРЛОГО | 4,342.1 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 3,047.4 |
| НИЙТ АШИГ | 1,294.7 |
| Боловсон хүчний холбогдолтой зардал | 177.3 |
| Ерөнхий удирдлагын бусад зардал | 270.8 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ | 448.0 |
| ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ | 846.7 |
| Санхүүгийн зардал | 84.6 |
| Ердийн бус орлого зардал | 23.0 |
| ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО | 785.1 |
| Татварын зардал | 44.0 |
| ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ | 741.1 |





ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

Компанийн үйл ажиллагаанд дотоод аудит болон ТУЗ-өөс өгсөн эрсдлийг бууруулах зөвлөмж ба түүний мөрөөр 2019 оны эхний хагас жилд хийсэн ажлуудыг дурьдвал:

- Дотоод аудитын ажлыг эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгож хэвшүүлэх, удирдлагын мэдээллийн системийг оновчтой болгоход чиглүүлж, ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.
- 2019 онд ургацын даатгалд 212 га талбайг хамруулж, нийт талбайд ган болон хяруу тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлдэг цуврал бордоог ашигласан.
- Зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд үйлдвэрлэлээ тогтвортой явуулж, бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд тогтмол нийлүүлж, бүтээгдэхүүний чанарт анхаарч байна. Мөн бүтээгдэхүүний үнийг харьцангуй тогтвортой байлгах бодлогыг баримталж байна.
- Компани 2019 оны ургац хүртэл үйлдвэрлэлээ тогтвортой явуулах түүхий эдийн нөөцийг бүрдүүлж чадсан боловч түүхий эдийн чанараас хамаарч гурилын үйлдвэрлэл төлөвлөсөн хэмжээнд хүрсэнгүй.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, чанарын хяналтыг сайжруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлээ. Энэ ажлын хүрээнд ажиллагсдын амрах байрыг шинэчлэн барьж, гурилын үйлдвэрт их засвар хийн, лабораторын хэсгийг өргөтгөлөө.



ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



- 2018 онд хувьцаа нэмж гаргах үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэнтэй холбоотойгоор дүрмийн сангийн өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулж УБГ бүртгүүлж, татварын албанд бүртгэлийг хийлгэж баталгаажуулав.
- Хөвсгөл Алтандуулга ХК-ийн хувьцаа нь 2019 оны 1-р сарын 15-ны өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын дагуу ТОП-20 индексийн багцыг 2019 онд бүрдүүлэх үнэт цаасаар шалгарч, сагсыг бүрдүүлэгч болов.
- Хувьцааны ханш 2019 оны эхний хагас жилд 665-1040 төгрөгийн хооронд арилжаалагдсан байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцааны арилжаа явагдсан өдрийн тоо 6 дахин сайжирч, нийт арилжааны үнийн дүн 2.4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
- Хөвсгөл Алтандуулга ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн №02 тоот тогтоолоор компанийн хуримтлагдсан цэвэр ашгаас нэгж хувьцаанд 120 төгрөг тараах шийдвэр гарсан. Тус шийдвэрийн дагуу 2019 оны 5-р сарын 1-ны өдрөөс хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгож эхлэв.





ЧАНАРЫН УДИРДЛАГА, ХАБЭА

Чанарын удирдлага

- БНХАУ-д бүтээгдэхүүн экспортлох гурилын үйлдвэрүүдийг магадлан итгэмжлэх хяналтанд хамрагдлаа. Энэхүү магадлан итгэмжлэл авах ажлын хүрээнд боловсруулах үйлдвэрлэл болон газар тариалангийн үйлдвэрлэл чанарын хяналтын тогтолцоогоо сайжруулж, ажиллагсдыг сургалтанд хамруулах ажлууд цогцоор хийгдсэн.
- Бүтээгдхүүний аюулгүйн тэмдгийн гэрчилгээ авах бэлтгэл ажлыг хангаж, Монгол улсын хүнсний аюулгүйн гэрчилгээг хүлээн авсан 7 дахь аж ахуйн нэгж болж чанарын баталгаажуулалтыг шинэчлэгдсэн дүрэм журмын дагуу авлаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

- Ажиллагсдын ажлын байрны тав тухтай байдлыг хангах, стандартын шаардлагад бүрэн нийцүүлэх зорилгоор ажиллагсдын хоолны газар, гал тогоог ажлын байранд ойртуулж, бие засах газар, хогийн цэг зэргийг шинээр барьж тохижуулав.
- Хагас жилийн хугацаанд ХАБЭА, хувь хүний хөгжил, стандартууд хэвшүүлэх чиглэлээр нийт 15 сургалт зохион байгуулагдсан байна.
- Ажиллагсдыг эрүүл мэндийн хуваарьт үзлэг хамруулахаас гадна Улаанбаатар хотоос нарийн мэргэжлийн эмч нарыг авчран үзлэгт хамрууллаа
- ХАБЭА-н дүрэм журам, стандартуудыг шинэчлэн баталж аюулгүй ажиллагааны заавар, сануулга, таних тэмдгийг шинэчлэн байрлуулав.

